

- Сангийн яамны урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөтэй уялдсан хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр зохион байгуулалтын бүтэц, хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулах;
- Сангийн яамны газар, хэлтэс, нэгжүүдийн чиг үүргийн шинжилгээг 2018 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн Монгол улсын Засгийн газрын тогтоол №22-д баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-аар шинжлэн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах,
- Албан хаагчдад тавигдах ур чадвар, туршлагын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох шинжилгээг 2 жил тутам хийх;


5.2. ТӨРИЙН АЛБАНЫ ТОМИЛГОО

Сангийн яамны мэргэжилтэн “5P” загвараар ажиллах шаардлагатай. Үүнд:

1. People- Олон нийт- ард түмнээ ойлгож мэддэг байх;
2. Private sector- Хувийн хэвшил- аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг мэддэг;
3. Professional institutions & NGO- Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагуудтай хэрхэн хамтран ажиллахыг мэддэг байх;
4. Public sector - Төрийн албаны мэдлэгтэй байх;
5. Partnership – Түншлэл хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах чадвартай байх;

Дээрх шаардлагыг хангахын тулд төрийн албаны томилгоог дор дурдсан үнэлгээний хөтөлбөрийг боловсруулан сонгон шалгаруулж томилно.

5P-Загварын зураглал



- **Мэргэжлийн ур чадвартай** - Монгол Улсын санхүү, эдийн засгийн бодлогыг боловсруулах, шийдвэр гаргах чадвартай;
- **Дадлага туршлагатай** - Хувийн хэвшлийг ойлгож үйлчилдэг, төрийн бус байгууллага болон мэргэжлийн байгууллагын мэдлэг зөвлөмжийг хүлээн авах чадварт суралцсан;
- **Төлөвшилттэй**- Ард түмний эрх ашгийг үндсээ болгосон ёс зүйтэй төрийн албан хаагч байна;

5.3. СУРГАЛТ ХӨГЖИЛ

- **Удирдан зохион байгуулах чадвар эзэмшүүлэх** зорилгоор стратеги удирдлага, хүний нөөцийн удирдлага, асуудал шийдвэрлэх чадвар, удирдлагын харилцааны ур чадварын сургалтад үе шат, давтамжтай бэлтгэх **УДИРДАХ АЖИЛТНЫ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР**-ийг хэрэгжүүлж ажиллана;
- **Мэргэжлийн ур чадварыг эзэмшүүлэх** зорилгоор стратеги төлөвлөлт, санхүүгийн менежмент, гүйцэтгэлийн менежмент, бодлогын шинжилгээ, хяналт, үнэлгээ хийх зэрэг асуудлаар мэдлэг чадвар бий болгох, дотоод, гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлуулах, дээд түвшний удирдах албан хаагчдын залгамж халааг бэлтгэх зорилтот сургалтад хамруулах, **ХУВЬ ХҮНИЙ ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР**-ийг хэрэгжүүлж ажиллана;
- **Дадлага туршлага** эзэмшүүлэхийн тулд мэргэжилтнийг **СЭЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**-ийн дагуу ажиллуулж ажлын байран дээр нь сургана;
- **Төлөвшил**- ажилтны төлөвшил нь харилцаа, хандлага, зан чанараар тодорхойлогдоно. Ажилтны төлөвшилийг үнэлж, дүгнэхэд хамт олны үнэлгээг хэрэглэх ба жилд нэг удаа 360 градусын аргачлалаар үнэлж, түүний үндсэн дээр явуулах үйл ажиллагааг **ХАМТ ОЛНЫ ТӨЛӨВШИЛ**-ийн хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ;


5.4. КАРЬЕР ХӨГЖИЛ

Төрийн албаны тухай хуулийн 26.3-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан ажилтан доорх замналын үе шатны дагуу албан тушаал ахих **КАРЬЕР ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР**-ийг хэрэгжүүлэн ажиллана.

Сангийн яамны мэргэжилтнүүдийн албан тушаалын замналыг тус хөтөлбөрийн 5.2-д заасан төрийн албаны томилгоо хийх үнэлгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар нээлттэй шударгаар мөрдөнө.

Сангийн яамны мэргэжилтнүүдийн албан тушаалын замнал

Зураг 1 Карьер хөгжлийн үе, шат



5.5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Сангийн яамны үйл ажиллагаатай уялдуулан Засгийн газрын 2019 оны 37 болон 38-р тогтоолоор баталсан журмын дагуу АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-ний төлөвлөгөө боловсруулж, ажилтан тус бүрийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэнэ.

Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний төлөвлөгөө боловсруулахдаа Монгол улсын засгийн газрын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг үндэс болгон мөрдлөг болгон ажиллана.

5.6. НИЙГМИЙН БАТАЛГАА

Нийгмийн түншлэлийн зарчимд тулгуурласан албан хаагчдын нийгмийн баталгаа, халамж, хамгааллыг дээшлүүлэх бодлого, хөтөлбөрийг хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын санхүү- эдийн засгийн боломжид нийцүүлэн хэрэгжүүлэх;

- **Ажлын орчин** – Эрүүл, аюулгүй, тав тухтай ажлын байрыг бий болгох;
- **Баталгаатай ажлын байр** - Суралцан хөгжих боломжийг хангахуйц “СУРГАЛТ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР”- ийг боловсруулан хэрэгжүүлэх;
- **Нийгмийн баталгааг хангасан ажлын байр**–“ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨТӨЛБӨР”, “ОРОН СУУЦНЫ ХӨТӨЛБӨР, “ГЭР БҮЛ, ХҮҮХДИЙН ХӨТӨЛБӨР”-ийг боловсруулан хэрэгжилтийг хангах.

5.7. ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРЛАГАД ЭРСДЭЛИЙГ ТООЦОХ

Хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаанд гарах алдаа, дутагдлыг урьдчилан тооцож, сэргийлэх арга замыг тодорхойлж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

Хүний нөөцийн эрсдэлийн хөтөлбөрт:

1. Хүний нөөцийн бодлогын эрсдэл
2. Хүний нөөцийн үйл ажиллагааны эрсдэл гэсэн хоёр бүлэг байна.

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулснаар Хүний нөөцийн бодлогын эрсдэлийг бууруулж эрсдэлгүй болгох боломжтой. Хүний нөөцийн үйл ажиллагааны эрсдэлийг орон тоо, бэлэн байдал, шилжилтийн эрсдэл, мөн хүний нөөцтэй холбоотой санхүү, хууль, мэдээллийн эрсдэл гэсэн чиглэлүүдээр тус бүрд нь жил, улирал, сарын төлөвлөгөөндөө Сангийн яамны алба, хэлтэс, нэгж бүр тусган ажиллах нь зүйтэй.

6. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЕХАНИЗМ

6.1. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Гүйцэтгэгч
1	Зохион байгуулалтын бүтцэд шинжилгээ хийх, өөрчлөгдөх шаардлагатай эсэхийг тодорхойлох	4 жил тутам	ТЗУГ
2	Ажлын байрны шинжилгээ хийх, шаардлагатай өөрчлөлт оруулах	2 жил тутам	ТЗУГ
3	Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ	Сар тутам	ТЗУГ
4	Албан хаагчдын карьер хөгжлийн төлөвлөлт	Жил тутам	Хүний нөөцийн мэргэжилтэн, менежер, тухайн албан хаагчтай хамт
5	Урамшууллын бодлого, үнэлгээтэй уялдуулах	2 жил тутам	ТЗУГ
6	Нийгмийн баталгааны бодлого	4 жил тутам	ТЗУГ
7	Сургалт хөгжлийн бодлого	2 жил тутам	ТЗУГ
8	Удирдах албан хаагчийг сургах, хөгжүүлэх бодлого	Тухай бүр	ТЗУГ
9	Хөдөлмөрлөх орчин, соёлын бодлого	2 жил тутам	ТЗУГ

Сангийн яамны удирдлагаас баталсан “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2019-2029”-ийн үндсэн зориулалтыг хангахын тулд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 3 жил тутам гаргаж батлуулан, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж ажиллана.

Хүний нөөцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд бүрэлдэхүүн хэсгүүд тодорхой төсөв, үйл ажиллагааг төлөвлөн, баталж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.